

## 2024 ОНЫ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН: АНХААРАЛ ТАТАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

2025 оны 6 дугаар сар

Үндэсний аудитын газраас Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланд тусгагдсан анхаарал татаж буй бодлого, зарчмын шинжтэй зарим асуудлыг түүвэрлэн танилцуулж байна.

### 1. 2024 онд Төсвийн хүрээний мэдэгдэлд 2 удаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

- 2024 оны төсөв болон төсвийн тодотгол батлах үед Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг зөрчиж Төсвийн хүрээний мэдэгдэлд 2 удаа өөрчлөлт оруулсан нь дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн үр нөлөөг бууруулж, төсвийн тогтвортой байдлын зарчмыг алдагдуулсан;
- Төсвийн орлогыг анхны баталснаас 36.4%, зарлагыг 32.6% нэмсэн өмнө нь байгаагүй өндөр тэлэлт юм.

### 2. Татварын нийт орлогын 26.7% хууль бус байх магадлалтай байна.

Татварын байгууллагаас гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй НӨАТ-ын хий бичилттэй холбоотой 950 тэрбум төгрөг, бусад гэрээ, ажил үйлчилгээ, мөнгө угаасан байж болзошгүй 6.37 их наяд, нийт 7.3 их наяд төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн нь нийт татварын орлогын 26.7%-тай тэнцүү байна.

### 3. 2024 оны зарлагын бодлогын үр дүн тодорхойгүй байна.

- Төсвийн бодлогын хүрэхээр төлөвлөсөн үр дүн, шалгуур үзүүлэлтүүд тодорхой бус, бодлогын хэрэгжилтийг гүйцэтгэлтэй уялдуулан нэгтгэн дүгнээгүй, төсвийн зарлагын үр нөлөөг үнэлэх боломжгүй байна.
- 2024 оны төсвийн нийт зарлага өмнөх оны гүйцэтгэлээс 49.3% өссөн.
- Зарлагын гүйцэтгэл 91.1% байна, дутуу гүйцэтгэлийн 80.2% нь хөрөнгийн зардал байгаа нь хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын гүйцэтгэл буурсныг харуулж байна.

### 4. 32,314 албан хаагчдын сүлжээний бус цалинд нийт 71.5 тэрбум төгрөг олгосон.

- Шинээр улсын төсвийн байгууллагад 594 албан хаагч нэмэгдсэн
- Төрийн албан хаагчдын цалин, урамшууллын нийт хэмжээ 157.7%-иар нэмэгдсэн
- Улсын төсөвт үйлдвэрийн газруудад 4,570 албан хаагчийг сүлжээний бус ангилалд бүртгэж, нийт 18.5 тэрбум төгрөгийн цалин хөлс олгосон
- Төрийн захиргааны болон үйлчилгээний газрын 430 байгууллагын 27,744 албан хаагчийг сүлжээний бус ангилалд бүртгэж, нийт 53 тэрбум төгрөгийн цалин хөлс олгосон.

### 5. Гадаадын зээл тусламжийн 21%-ийг эдийн засгийг үр ашиггүй, эргэн төлөгдөх чадамжгүй төслүүдэд зарцуулсан байна. Аудитын шалгалтаар энэхүү асуудалтай 433.8 тэрбум төгрөгийн нийт 34 төсөл байна.

- 6. Эрүүл мэндийн даатгалд иргэдийн үүрэг суларсан.**
- ЭМДС-ийн орлогын 55.7%-ийг төр хариуцах иргэдийн шимтгэл эзэлж байгаа ба эдгээр иргэний тоо 83,043 хүнээр өссөн. Харин өөрөө хариуцагч иргэдийн тоо 27,819 хүнээр буурсан байна.
- 7. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын нэмэлт орлого олох, түүнийгээ зарцуулах явдал огцом ихэссэн.**
- Нийт 1.16 их наяд төгрөгийн санхүүжилт, өмнөх оны гүйцэтгэлээс орлого 37.6%, зарлага 37.4% өссөн байна.
- 8. Орон нутгийн өр огцом өссөн, зориулалтын дагуу ашиглаагүйн улмаас 5.7 тэрбумын алдагдал үүсээд байна.**
- Нийслэлийн ЗДТГ-аас нийт 2.5 их наяд төгрөгийн үнэт цаас гаргасан.
  - “Сэлбэ дэд төв” төсөлд зориулан 2024 оны 11 дүгээр сард гадаадад гаргасан 500 сая ам. долларын жилийн 7.75% хүүтэй бондыг ашиглаж эхлээгүй, арилжааны банкуудад байршуулсан байна.
  - Бондын эх үүсвэрийг ашиглаагүйн улмаас хүүгийн болон ханшийн зөрүүгээр нийт 5.7 тэрбум төгрөгийн алдагдал үүссэн.
  - Өрийн удирдлагын тухай хуулийн “арилжааны зээлийг эх үүсвэрээр эргэн төлөгдөх чадвартай төсөл санхүүжүүлэх” гэсэн 6.4.2 дахь заалтыг зөрчсөн.
- 9. Засгийн газар аудитын зөвлөмжийг үл тоомсорлож ирлээ.** Өмнөх оны УАГ-ын зөвлөмжийг 54.3% хэрэгжилттэй гэж дүгнэсэн.
- 10. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 66.4%-тай байгаа нь хангалтгүй үзүүлэлт байна.**
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр шинэ болон шилжих 4922 төсөл, арга хэмжээнд тайлант онд 3.28 их наяд төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталж, гүйцэтгэлээр 4137 ТАХ-нд 2.18 их наяд төгрөг буюу 66.4 хувийн санхүүжилт олгосон.
  - Орон нутгийн төсвийн нийт хөрөнгө оруулалтын 72.3%-ийг, шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн 83.7%-ийг тус тус эзэлдэг нийслэлийн хөрөнгө оруулалтын төсвийн гүйцэтгэл дөнгөж 60.2%-тай гарсан нь голлон нөлөөллөө.
  - Нийслэлийн шинэ төсөл, арга хэмжээний 70%-ийг “Метро” барих бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.
- 11. Шинээр хэрэгжүүлэхээр баталсан барилга байгууламжийн ангилалд хамаарах 700 төсөл арга хэмжээний 23.8%-д нь төсвийн хууль, журмыг мөрдөөгүй байна.**
- Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянан, тайлагнах” журмын 2.2.4-д шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд хууль, журамд заасан үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлт, тооцооллыг гаргаж хавсаргахаар тусгасан.
- 12. Барилга байгууламж, их засварын ангилалд хамаарах 700 төсөл, арга хэмжээнээс 49.7% буюу 348 төсөл, арга хэмжээ нь зураг төсөвгүй байна.** Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д “хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, магадлалаар баталгаажсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасан.

## ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг Нээлттэй нийгэм форумын дэргэдэх Эдийн засгийн зөвлөл хэлэлцэн дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Төсвийн хүрээний мэдэгдэл батлагдсаны дараа төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр төсвийн хязгаарыг баталдаг Засгийн газрын тогтоол нь эрх зүйн мандатгүй, УИХ-ын эрх мэдлээс гадуур хийгдэж байна. УИХ-ын төслүүдийг хэлэлцэх эрхийг эрх зүйн шинэ зохицуулалтаар тодорхой болгох;
2. Аудитын тайланг УИХ нухацтай, дэлгэрэнгүй сайн хэлэлцэж байх /одоогоор 1-2 хоногт маш яаралтай горимоор хэлэлцэж байгаа/;
3. Аудитын зөвлөмжийг биелүүлээгүй албан тушаалтанд хатуу хариуцлага тооцох – жилээс жилд зөвлөмжийн хэрэгжилт 50-60% байгаа ч хариуцлага хүлээсэн ТЭЗ байхгүй байна. 2024 онд Ерөнхий сайд 5 зөвлөмжийн 2-ыг огт биелүүлээгүй боловч хариуцлага тооцоогүй;
4. Засгийн газар болон ТЭЗ нар аудитын зөвлөмжийн хэрэгжилт, авсан арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлдэг болохыг шаардах. Одоогоор ҮАГ-т албан тоот хүргүүлэх /ихэнхдээ заасан хугацаа хэтэрсэн хойно, зарим тохиолдолд огт хариу өгөхгүй байгаа/ төдийгөөр хязгаарлаж байгаа нь төрийн хяналтын утга учрыг алдагдуулж байна;
5. Төсвийн явцын гүйцэтгэлээр хагас жилд нэг удаа УИХ дээр сонсгол, танилцуулга хийдэг болох;
6. Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, хөрөнгө оруулалтын ангиллыг нарийвчлах. Урсгал зардлын шинжтэй, өгөөжгүй, нийтийн зориулалтгүй төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтад хамааруулахгүй байхаар хуульчлах;
7. Аймаг, нийслэл, сумдын ИТХ-д тавих хяналтыг эрчимжүүлэх эрх зүйн зохицуулалт бий болгох. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавигдах үндэслэл, ТЭЗҮ, зураг төсөвтэй байх шалгуур бий болгох;
8. Нийслэлийн гадаад бондын ашиглалтын асуудлаар төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах.